

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/198/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭСАНТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/102
танай -ны № -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны эцэст 328,550.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 27,703.7 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг гүйцэтгээгүй, нягтлан бодогч тооцоо бодсон баримтаар үр дүнг тооцож баталгаажуулаагүй, 5,423.4 төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэлгүй шууд зардалд тусган тайлагнасан зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 72.4.1-д "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Иж бүрэн байх", "Үнэн зөв байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

19020336

D 2022/2022 он/ALBAN BICHIG

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,854,189.73	32,426,422.65
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	4,722,710.67
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	4,722,710.67
3121	Төгрөг	00.00	4,722,710.67
31211	Төрийн сангийн харилцах	00.00	4,602,710.67
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	120,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	14,854,189.73	27,703,711.98
351	Түүхий эд материал	13,400,189.73	27,703,711.98
35110	Тусгай зориулалттай материал	7,323,500.00	10,955,295.45
35130	Эм боох материал	6,076,689.73	16,748,416.53
354	Хангамжийн материал	1,454,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	1,454,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	348,655,743.15	328,550,814.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	348,655,743.15	328,550,814.84
392	Биет хөрөнгө	332,513,743.15	312,408,814.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	243,514,269.00	243,514,269.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-26,632,236.02	-37,557,328.82
39203	Авто-тээврийн хэрэгсэл	106,280,000.00	121,480,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-65,061,333.18	-74,082,888.70
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	224,506,288.15	179,265,563.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-152,422,859.72	-121,417,165.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,506,832.95	10,506,832.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,086,874.03	-10,210,123.51
39214	Бусад үндсэн хөрөнгө	64,900.00	64,900.00
39217	Ном	844,756.00	844,756.00
393	Биет бус хөрөнгө	16,142,000.00	16,142,000.00
39301	Програм хангамж	634,000.00	634,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-634,000.00	-634,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,142,000.00	16,142,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	363,509,932.88	360,977,237.49
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	363,509,932.88	360,977,237.49
51	Засгийн газрын хувь оролцоо	363,509,932.88	360,977,237.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	311,267,812.78	311,267,812.78
51101	Өмч: - төрийн	295,125,812.78	295,125,812.78
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	16,142,000.00	16,142,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	-79,821,587.19	-81,900,863.92
51210	Өмнөх үеийн үр дүн	-79,821,587.19	-79,368,168.53
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-2,532,695.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	132,063,707.29	131,610,288.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	363,509,932.88	360,977,237.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	485,551,010.34	905,416,682.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,085,562.34	305,981,927.82
120	Нийтлэг татварын бус орлого	27,963,662.34	276,001,537.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,963,662.34	276,001,537.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	835,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	27,963,662.34	275,166,537.82
122	Тусламжийн орлого	29,121,900.00	29,980,390.00
122001	Хандив тусламж /дотоод/	29,121,900.00	29,980,390.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	44,926,048.00	157,024,055.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	383,539,400.00	442,410,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,406,248.00	113,120,755.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,406,248.00	113,120,755.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,519,800.00	43,903,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,519,800.00	43,903,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	536,828,513.48	682,559,093.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	536,828,513.48	682,559,093.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,326,535.10	668,588,012.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	316,887,874.15	346,374,217.84
210101	Үндсэн цалин	233,345,468.65	222,134,113.22
210102	Нэмэгдэл	58,908,874.50	83,902,704.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,288,600.00	5,263,000.00
210104	Урамшуулал	21,344,931.00	35,074,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,828,382.77	45,000,887.49
210201	Тэтгэврийн даатгал	29,886,664.10	34,018,903.13
210202	Тэтгэмжийн даатгал	3,239,141.27	3,011,876.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,223,070.38	2,392,701.26
210204	Ажилгүйдлийн даатгал	150,599.73	507,036.95
210205	Эрүүл мэндийн даатгал	5,328,907.29	5,070,369.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,786,134.00	28,632,219.00
210301	Гэрэл, цахилгаан	2,253,661.00	1,974,975.00
210302	Түлш, халаалт	26,172,473.00	26,297,244.00
210303	Цэвэр, бохир ус	360,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,036,290.00	42,064,392.00
210401	Бичиг хэрэг	1,657,110.00	1,999,300.00
210402	Тээвэр, шатахуун	21,642,080.00	36,067,592.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,135,000.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,602,100.00	1,997,500.00
2105	Нормативт зардал	36,199,812.96	52,850,509.91
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,037,162.96	43,355,009.91
210502	Хоол, хүнс	9,162,650.00	9,495,500.00

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,313,132.00	5,540,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	607,532.00	502,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,738,900.00	3,737,500.00
210604	Урсгал засвар	966,700.00	1,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,750,000.00	2,500,000.00
210702	Дотоод албан томилолт	1,750,000.00	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,035,908.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,645,908.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	66,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,489,001.22	145,625,586.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,188,590.00	80,600,700.29
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,300,411.22	65,024,885.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,501,978.38	13,971,081.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,501,978.38	13,971,081.00
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	8,501,978.38	13,971,081.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-51,277,503.14	222,857,589.42
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,881,986.48	225,390,284.81
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	10,881,986.48	225,390,284.81
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-10,881,986.48	225,390,284.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-62,159,489.62	-2,532,695.39

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,267,812.78	132,063,707.29	-17,662,097.57	425,669,422.50
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	311,267,812.78	132,063,707.29	-17,662,097.57	425,669,422.50
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-62,159,489.62	-62,159,489.62
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,267,812.78	132,063,707.29	-79,821,587.19	363,509,932.88
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,267,812.78	132,063,707.29	-79,821,587.19	363,509,932.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	311,267,812.78	132,063,707.29	-79,821,587.19	363,509,932.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,532,695.39	-2,532,695.39
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,267,812.78	132,063,707.29	-82,354,282.58	360,977,237.49

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	457,587,348.00	630,250,145.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,121,900.00	30,815,390.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	835,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	835,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	835,000.00
122	Тусламжийн орлого	29,121,900.00	29,980,390.00
122001	Хандив тусламж /дотоод/	29,121,900.00	29,980,390.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	428,465,448.00	599,434,755.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	383,539,400.00	442,410,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,406,248.00	113,120,755.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,406,248.00	113,120,755.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,519,800.00	43,903,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,519,800.00	43,903,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	457,587,348.00	625,527,434.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	457,587,348.00	625,527,434.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,085,369.62	610,548,353.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	316,887,874.15	346,147,698.71
210101	Үндсэн цалин	233,345,468.65	221,907,594.09
210102	Нэмэгдэл	58,908,874.50	83,902,704.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,288,600.00	5,263,000.00
210104	Урамшуулал	21,344,931.00	35,074,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,828,382.77	45,227,406.62
210201	Тэтгэврийн даатгал	29,886,664.10	33,205,613.26
210202	Тэтгэмжийн даатгал	3,239,141.27	3,298,215.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,223,070.38	2,621,772.26
210204	Ажилгүйдлийн даатгал	150,599.73	554,708.95
210205	Эрүүл мэндийн даатгал	5,328,907.29	5,547,096.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,786,134.00	28,632,219.00
210301	Гэрэл, цахилгаан	2,253,661.00	1,974,975.00
210302	Түлш, халаалт	26,172,473.00	26,297,244.00
210303	Цэвэр, бохир ус	360,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,071,290.00	32,470,892.00
210401	Бичиг хэрэг	1,692,110.00	1,999,300.00
210402	Тээвэр, шатахуун	21,642,080.00	26,474,092.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,135,000.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,602,100.00	1,997,500.00
2105	Нормативт зардал	22,287,966.70	26,034,882.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,125,316.70	16,539,382.00

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	9,162,650.00	9,495,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,603,500.00	8,396,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,072,900.00	2,999,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,338,900.00	4,097,500.00
210604	Урсгал засвар	1,191,700.00	1,300,000.00
2107	Томиллолт, зочны зардал	1,750,000.00	2,500,000.00
210702	Дотоод албан томиллолт	1,750,000.00	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,381,632.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,991,632.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	66,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,488,590.00	121,138,555.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,488,590.00	121,138,555.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,501,978.38	14,979,081.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,008,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,501,978.38	13,971,081.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	4,722,710.67
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	4,722,710.67
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	4,722,710.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	531,166,400.0	497,720,598.3	33,445,801.7	93.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	531,166,400.0	497,720,598.3	33,445,801.7	93.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531,166,400.0	497,720,598.3	33,445,801.7	93.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	361,972,400.0	346,147,698.7	15,824,701.3	95.6
210101	Үндсэн цалин	233,829,200.0	221,907,594.1	11,921,605.9	94.9
210102	Нэмэгдэл	86,516,800.0	83,902,704.6	2,614,095.4	97.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,552,000.0	5,263,000.0	1,289,000.0	80.3
210104	Урамшуулал	35,074,400.0	35,074,400.0	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,866,300.0	45,227,406.6	3,638,893.4	92.6
210201	Тэтгэврийн даатгал	34,387,400.0	33,205,613.3	1,181,786.7	96.6
210202	Тэтгэмжийн даатгал	3,619,700.0	3,298,215.6	321,484.4	91.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,895,800.0	2,621,772.3	274,027.7	90.5
210204	Ажилгүйдлийн даатгал	723,900.0	554,709.0	169,191.1	76.6
210205	Эрүүл мэндийн даатгал	7,239,500.0	5,547,096.6	1,692,403.4	76.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,603,300.0	28,632,219.0	13,971,081.0	67.2
210301	Гэрэл, цахилгаан	5,056,800.0	1,974,975.0	3,081,825.0	39.1
210302	Түлш, халаалт	37,183,500.0	26,297,244.0	10,886,256.0	70.7
210303	Цэвэр, бохир ус	363,000.0	360,000.0	3,000.0	99.2
2104	Хангамж, бараа материалын зардал	32,385,000.0	32,381,792.0	3,208.0	100.0
210401	Бичиг хэрэг	2,000,000.0	1,999,300.0	700.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	26,385,000.0	26,384,992.0	8.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.0	2,000,000.0	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.0	1,997,500.0	2,500.0	99.9
2105	Нормативт зардал	26,039,400.0	26,034,882.0	4,518.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,539,400.0	16,539,382.0	18.0	100.0
210502	Хоол, хүнс	9,500,000.0	9,495,500.0	4,500.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,400,000.0	8,396,700.0	3,300.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.0	2,999,200.0	800.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,100,000.0	4,097,500.0	2,500.0	99.9
210604	Урсгал засвар	1,300,000.0	1,300,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,500,000.0	2,500,000.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	2,500,000.0	2,500,000.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,400,000.0	8,399,900.0	100.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,400,000.0	8,399,900.0	100.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	531,166,400.0	502,323,309.0	28,843,091.0	94.6

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	442,410,700.0	442,410,700.0	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	442,410,700.0	442,410,700.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,903,300.0	29,932,219.0	13,971,081.0	68.2
132001	Орон нутгийн төсвөөс	43,903,300.0	29,932,219.0	13,971,081.0	68.2
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	44,852,400.0	29,980,390.0	14,872,010.0	66.8
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	44,852,400.0	29,980,390.0	14,872,010.0	66.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,602,710.7	(4,602,710.7)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	113,835,755.00	113,835,755.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	113,835,755.00	113,835,755.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	112,827,755.00	112,827,755.00
2104	Хангамж, бараа материалын зардал	89,100.00	89,100.00
210402	Тээвэр, шатахуун	89,100.00	89,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,738,655.00	112,738,655.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,738,655.00	112,738,655.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,008,000.00	1,008,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00	1,008,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	113,955,755.00	113,955,755.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	113,955,755.00	113,955,755.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	113,120,755.00	113,120,755.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	120,000.00	120,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	120,000.00	120,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад НББ-ийн аккурэл сууриар хөтөлж тайлагнах, бараа материалыг шууд зардлаар бүртгэхгүй байх, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгүүдийг шийдвэрлэх, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Жишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлж, иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэхийг зорилгоо болгон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/04 дугаар тушаалаар дотоод хяналтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. Тайлант онд дотоод хяналтын баг нь ЭМТ-ийн даргын баталсан хяналт үнэлгээ хийх удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалт хийж ажилласан байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төв нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө, Төв аймгийн Засаг дарга бөгөөд дотоод аудитын хорооны даргын баталсан удирдамжийн дагуу 2019, 2020 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 486,314.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 7,294.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,471.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 442,410.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 43,903.3 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 44,852.4 санхүүжилт

авахаас, улсын төсвөөс 442,410.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 29,932.2 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 29,980.4 мянган төгрөгийн, нийт 502,323.3 мянган төгрөгийн буюу 94.5 хувийн санхүүжилт авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 113,835.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 622,977.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 19,900.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 25,019.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 44,919.9 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,550.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 42,369.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 232,796.6 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 140,964.3 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 360,911.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тус Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнасан байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн дансанд 4,602.7 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансанд 120.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлгүй байна. Бараа материал 27,703.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 328,550.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	4,722.71	4,722.71
Авлага	-	-	-
Урьдчилгаа			-
Бараа материал	14,854.19	27,703.71	12,849.52
Үндсэн хөрөнгө	348,655.74	328,550.81	(20,104.93)
Нийт хөрөнгө	363,509.93	360,977.24	(2,532.70)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	363,509.93	360,977.24	(2,532.69)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	363,509.93	360,977.24	(2,532.69)

Бараа материалын дансны үлдэгдэл 27,703.7 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 12,849.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 328,550.8 мянган төгрөг болж 20,104.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 360,977.2 мянган төгрөг болж 2,532.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 531,166.4 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 531,166.4 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 531,166.4 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 442,410.7 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 29,932.2 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 29,980.4 мянган төгрөгийн, нийт 502,323.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 497,720.6 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 4,602.7 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 497,720.6 мянган төгрөг буюу 93.7 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 113,955.8 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний бусад зардалд 112,827.8 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 1,008.0 мянган төгрөгийг зарцуулж, 120.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Эрдэнэсант сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолоор тус Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглагдах боломжгүй 117 нэр төрлийн 74,960.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 6 нэр төрлийн 14,736.1 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж тайланд тусгасан.

Эрүүл мэндийн даатгалын сангаас Коронавируст халдвар /Ковид-19/ -ын тусламж үйлчилгээний санхүүжилтийг хувийн хамгаалах хэрэгсэл, шаардлагатай эм, эмийн нөөц бэлтгэх, ариутгал халдваргүйжүүлэлт, өвчтөний хоол, улаан бүсэд ажилласан эмч, ажилчдын цалин зэрэгт бүрэн зарцуулж, уг үйл ажиллагааг санхүүгийн тайланд толилуулсан.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст 328,550.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 27,703.7 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг гүйцэтгээгүй, тооцоо бодсон баримтаар үр дүнг тооцож баталгаажуулаагүй, 5,423.4 төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэлгүй шууд зардалд тусган тайлагнасан зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70

дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 72.4.1-д "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккурэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг хэрэгжүүлээгүй, "Оршин байх", "Иж бүрэн байх", "Үнэн зөв байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 118 мэдээллийг хугацаандаа, 23 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвд санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 80,976.3 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 2,242.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 78,733.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулга хийх алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 2,242.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд албан хаагчдад 17,600.0 мянган төгрөгийн Вакцины урамшуулал цалин, 4,070.7 мянган төгрөгийн улаан бүсэд ажилласны илүү цагийн цалинг олгохдоо НДШ-ийг суутган тооцолгүй, зөвхөн ХХОАТ-ыг суутган тооцсоны улмаас 2,242.9 мянган төгрөгийн нэмэгдэл цалинг илүү олгосон нь: Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ, 1/Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна: 1/Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон нэмэгдэл цалинг холбогдох албан хаагчдаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн эргэлтийн хөрөнгийн тооллого хийгээгүй, тооллоготой холбоотой баримт материалыг аудитын байгууллагад ирүүлээгүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 5,423.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг бараа материалын орлого авалгүй өглөгийн данснаас шууд зардалд бүртгэсэн.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэсэнтэй тус тус

нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

НББ-ийн аккурэл сууриар хөтөлж, бараа материалыг шууд зардлаар бүртгэхгүй байх

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 33 нэр төрлийн 72,675.9 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх

3. Биет бүтээгдэхүүний данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 2 нэр төрлийн 634.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх

4. Шилэн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 118 мэдээллийг хугацаандаа, 23 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв, бүрэн мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төв	6	80,976.3	-	-	1	2,242.9	1	-	4	78,733.4

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn